



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/161.

Улаанбаатар хот

**Цэргийн албаны ээлжит халалт, татлагыг  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсаргалтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1116 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн жинхэнэ алба хааж хугацаа дуусч, бэлтгэлээр халагдсан байлдагч, түрүүчийг хүлээн авах арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 14-өөс 15-ны өдөрүүдэд, Дүүргийн 2024 оны хоёрдугаар ээлжийн цэргийн жинхэнэ албанд татах ажлыг 2024 оны 10 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Дүүргийн цэрэг татлага, эрүүл мэндийн үзлэгийн байраар дүүргийн дайчилгааны "Цугларах" байр буюу Ерөнхий боловсролын "Хангай" сургуулийн нэгдүгээр байрыг томилгоожуулан эрүүл мэндийн үзлэг явуулах боломжтойгоор төхөөрөмжлөн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллахыг "Хангай" сургууль (Э.Соёмбобат)-д, дүүргийн Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д үүрэг болгосугай.

3.Цэргийн жинхэнэ албанд татах ажлыг удирдан зохион байгуулах Цэрэг татлагын товчооны удирдлагын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар, хавсралтаар баталсугай

4.Цэрэг татлагын зардалд зарцуулагдах төсөв болох 6,567,800 (зургаан сая таван жаран долоон маянга найман зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй

5.Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг цэрэг татлагын товчоо удирдлагын бүрэлдэхүүнд даалгасугай:

5.1 Цэрэг татлагын товчооны дарга холбогдох албан тушаалтнуудад:

5.1.1Дүүргийн цэрэг татлагын товчооны гишүүдийн гүйцэтгэх ажил үүргийн хуваарийг нарийн тогтоож, хууль, эрх зүйн баримт бичгийг танилцуулан, заавар, зөвлөгөө өгч, гүйцэтгэлд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг өндөр түвшинд хэрэгжүүлж, Батлан хамгаалах сайдын 2024 оны 02 дугаар даалгавар, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2024 оны мн/204 дүгээр тушаал, 02/3285 дугаар албан даалгавар, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 1в/3493 дугаар албан даалгавар, Нийслэлийн Засаг

AJIL\2024 он ажил\захирамж

1123200391

даргын Тамгын газрын Цэргийн штабын 2024 оны мн/41 албан бичгээр ирүүлсэн хяналтын тоог биелүүлэх, "Төрийн захиргааны болон үйлчилгээний алба хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын дагуу амралтын өдрүүдэд ажилласан бие бүрэлдэхүүнд нөхөж нэмэгдэл хөлс олгохыг дүүргийн Цэрэг татлагын товчооны дарга (Л.Санжийжамц)-д:

5.1.2 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан "Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам"-ыг цэрэг татлагын эрүүл мэндийн байранд ажиллах эмч сувилагч нарт танилцуулах.

5.1.3 Цэргийн албанд татагдагч иргэдэд эрүүл мэндийн үзлэг явуулах байр, нарийн мэргэжлийн эмч сувилагч нарыг томилон, эрүүл ахуйн дэглэмийг баримталж, цэрэгт татагдагч болон цэрэг татлагаар ажиллах бие бүрэлдэхүүний ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг хуваарийн дагуу хийж мэргэжлийн удирдлагаар ханган, шинжилгээ оношилогоо хийх эмнэлгийн багаж төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж, захирамжид заасан өдрүүдэд эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд хүргэж эрүүл мэндийн улмаас тэнцээгүй иргэдийн нэрийн жагсаалтыг гарган эмчийн хяналтад авч эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д:

5.1.4 Цэрэг татлагын байрыг 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдрөөс 20-ны өдрүүдэд цагдаагийн хамгаалалтад авч, цэрэг халалт, татлагын үед нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, Цэрэгт татагдагчдыг тээвэрлэх тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдалд үзлэг шалгалт хийж, жолооч нарын үүрэг хариуцлагыг дээшлүүлэн зам, тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар шаардлагатай бүх арга хэмжээг авч, батлагдсан зам маршрутын дагуу цагдаагийн хамгаалалтын дор хүргэх.

5.1.5 "Зарлан дуудах мэдэгдэл" аваад тогтоосон хугацаанд, заасан байранд ирээгүй, эрүүл мэндийн үзлэгт орохоос зайлсхийсэн иргэдийн судалгааг холбогдох албан тушаалтнаас гаргуулан, Цэрэг татлагын товчооноос өгсөн нэрийн дагуу тодотгон шалгаж цэрэг татлагын байранд ирүүлэх, хууль тогтоомж зөрчсөн иргэнтэй хуулийн хариуцлага тооцохыг Цагдаагийн хэлтэст (Цагдаагийн хурандаа Т.Лхагвасүрэнд)-т:

5.1.6 Цэргийн жинхэнэ албанд татагдах тухай "Зарлан дуудах мэдэгдэл" аваад цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд ирээгүй болон цэргийн жинхэнэ албаны татлагаас удаа дараалан зайлсхийсэн хүмүүст Зөрчлийн тухай хуулийн 15.17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу захиргааны арга хэмжээ авахыг Цэргийн штаб (Хурандаа Ш.Бат-Өлзий)-т

5.1.7 Хугацаат цэргийн албанд татагдаж буй иргэдийн иргэний үнэмлэх, эрүүл мэнд, нийгмийн даатгал, гэнэтийн ослын даатгалд бүрэн хамруулж шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн хүргүүлэх

5.1.8 Цэргийн жинхэнэ алба хааж хугацаа дуусаж бэлтгэлээр халагдсан цэргийн үүрэгтнийг хүлээн авч, ажлын байраар хангах, сургалтад хамруулах, нийгмийн халамж үйлчилгээ хүргэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийгмийн даатгалын газар (Б.Баяртуяа), Хөдөлмөр Халамж үйлчилгээний хэлтэс (Д.Энхтайван)-т



5.1.9 Хугацаат цэргийн албаны ээлжит цэрэг халалт, татлагын ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган ажиллаж, албан хэрэг хөтлөлтийн стандартын шаардлагыг бүрэн хангасан маягтаар албан хэргийг хөтөлж, цэрэг татлага явуулсан тухай дүн мэдээг татлага дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор Нийслэлийн цэрэг татлагын товчоонд хүргүүлэхийг Цэргийн штаб (Хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай

5.1.10 Цэрэг, халах, татах арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлан ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Отгонжаргал)-д үүрэг болгосугай

5.2. Хороодын Засаг дарга нарт:

5.2.1 Ээлжит цэрэг татлагыг эрхлэн явуулах ажлын хэсгийг хорооны зохион байгуулагчаар ахлуулан байгуулж, захирамж гарган стандартын шаардлага хангасан маягтаар албан хэргийг хөтөлж, ажил үүргийн хуваарь, бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан хорооны ажилтнууд, хэсгийн ахлагч нарын гүйцэтгэх ажил үүргийг тодотгон зааварчилгаа өгч бэлтгэл ажлыг хангах, цэрэгт татагдагчдыг татлагад бүрэн хамруулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5.2.2 Цэрэг халалт, татлагын талаарх эрх зүйн баримт бичгүүдийг сурталчлах, цэрэг татлагын ажлыг хуулийн дагуу зохион байгуулж цэргийн насны иргэдийг баримт бичгийн болон эрүүл мэндийн шинжилгээнүүдийг бүрдүүлэн тогтоосон хугацаанд заасан газарт бэлэн байлгах талаар мэдээ мэдээллийг хүргэж хууль, эрх зүйн мэдээ мэдээлэл авах, лавлах утасны дугаарыг иргэдэд танилцуулж ажиллах;

5.2.3 Цэрэг татлагатай холбоотой мэдээ судалгааг тухай бүрд нь гарган дүүргийн Цэргийн штабт хүргүүлэх, мэдээллээр хангах, Цэргийн жинхэнэ алба хаасан залуучуудаас цэргийн гэрээт албанд элсүүлэх Цэргийн алба хаах төрлүүдийн талаар мэдээлэлтэй байж иргэдэд зөвлөн туслах ажлыг холбогдох хууль дүрэм, журмын дагуу зохион байгуулах;

5.2.4 Цэргийн насны залуучуудыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах ажлыг холбогдох албан тушаалтнууд, хууль сахиулах байгууллагуудтай хамтран зохион байгуулах


5.2.5 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Б.Болормаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 10 сарын 10-ны өдрийн 4/161  
захирамжийн нэгдүгээр хавсралт



ДҮҮРГИЙН ЦЭРЭГ ТАТЛАГЫН ТОВЧООНЫ  
УДИРДЛАГЫН БҮРЭЛДЭХҮҮН

|                       |               |                                                                    |
|-----------------------|---------------|--------------------------------------------------------------------|
| Товчооны дарга:       | Л.Санжийжамц  | Засаг даргын Тамгын газрын дарга                                   |
| Орлогч дарга:         | Ш.Бат-Өлзий   | Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа          |
| Гишүүдэд:             | Ц.Мягмарсүрэн | Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга                               |
|                       | Н.Батцэнгэл   | Төрийн захиргааны удирдлагын Хэлтсийн мэргэжилтэн                  |
|                       | Т.Лхагвасүрэн | Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа                     |
|                       | Д.Билгээ      | Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа            |
|                       | Х.Ганбат      | Эрүүл мэндийн төвийн дарга                                         |
|                       | Э.Соёмбобат   | Дүүргийн ерөнхий боловсролын “Хангай” цогцолбор сургуулийн захирал |
|                       | Н.Нямзав      | Нэгдүгээр хорооны Засаг дарга                                      |
|                       | Б.Батзориг    | Хоёрдугаар хорооны Засаг дарга                                     |
| Нарийн бичгийн дарга: | А.Баярбат     | Тоо бүртгэлийн офицер                                              |



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 10 сарын 10-ны өдрийн 1161  
захирамжийн хоёрдугаар хавсралт

2024 ОНЫ 2 ДУГААР ЭЭЛЖИЙН ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ ЦЭРЭГ ТАТАХ,  
ХАЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ЗАРЦУУЛАГДАХ МАТЕРИАЛ,  
ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| №                                                          | Материалын нэр                                                        | Хэмжих нэгж          | Тоо ширхэг             | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ  |
|------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|----------------------|------------------------|----------------|-----------|
| А. Шатахуун тослох материал                                |                                                                       |                      |                        |                |           |
| 1                                                          | Цэрэг татлагын товчооны нэгдсэн хуралд оролцох                        | литр (хийн түлш)     | 24л                    | 1950           | 46,800    |
| 2                                                          | Бэлтгэл ажил материал цуглуулах, татан авах, Цэрэг хүлээн авах, татах | литр (хийн түлш)     | 80л                    | 1950           | 156,000   |
| 3                                                          | Цэрэг тээврийн хамгаалалтын машин                                     | литр (АИ-92)         | 50 л                   | 2410           | 120,500   |
| 4                                                          | Цэргийн ангиудад цэрэг хүргэх тээвэрлэлтийн                           | литр (АИ-92)         | 80 л                   | 2410           | 192,800   |
|                                                            | Цэргийн ангиудад цэрэг хүргэх тээвэрлэлтийн                           | литр (хийн түлш)     | 100                    | 1950           | 195,000   |
| 5                                                          | Цэрэг татлагын мэдээ судалгаа хүргэх                                  | литр (хийн түлш)     | 24 л                   | 1950           | 46,800    |
| 6                                                          | Эмч нарыг авах, хүргэх                                                | литр (АИ-92)         | 40 л                   | 2410           | 96,400    |
| Шатахууны бүгд                                             |                                                                       |                      |                        |                | 854,300   |
| 7                                                          | Хулдаасан хэвлэл                                                      | м <sup>2</sup>       | 20                     | 21000          | 420,000   |
| 8                                                          | Стикер                                                                | 1,2 м <sup>2</sup>   | 2                      | 52000          | 104,000   |
| Хэвлэлийн бүгд                                             |                                                                       |                      |                        |                | 524,000   |
| 9                                                          | Цэрэг татлагын байранд ажиллах бүрэлдэхүүн хоол                       | Өглөөний цай         | 1 хоног ( 53 хүн өдөр) | 7000           | 371,000   |
|                                                            |                                                                       | Өдрийн хоол          | 1 хоног ( 53 хүн өдөр) | 19000          | 1,007,000 |
|                                                            |                                                                       | оройны хоол          | ( 53 хүн өдөр)         | 9000           | 477,000   |
| Хоол хүнсний бүгд                                          |                                                                       |                      |                        |                | 1,855,000 |
| Г. 2023 оны II ээлжийн цэрэг халах ажилд шаардагдах зардал |                                                                       |                      |                        |                |           |
| 12                                                         | Халагдсан дайчдыг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх, дурсамж хэвлүүлэх   | Хүн/тоо              | 30                     | 15000          | 450,000   |
| Д.Эрүүл мэндийн үзлэгт                                     |                                                                       |                      |                        |                |           |
| 14                                                         | Цэрэг татлагаар ажлуулах нарийн мэргэжлийн эмч нарын өдрийн цалин     | 1 хоног ( 1Хүн өдөр) | 4                      | 100,000        | 400,000   |

|                        |                                             |        |        |        |                  |
|------------------------|---------------------------------------------|--------|--------|--------|------------------|
| 15                     | АЛАТ                                        | Хүн    | 1 багц | 150000 | 150,000          |
| 16                     | АСАТ                                        | Хүн    | 1 багц | 160000 | 160,000          |
| 17                     | Кератин                                     | Хүн    | 1 багц | 140000 | 140,000          |
| 18                     | Сахар                                       | Хүн    | 1 багц | 130000 | 130,000          |
| 19                     | Шээсний шинжилгээний урвалж                 | Хүн    | 1 багц | 32000  | 32,000           |
| 20                     | Цусны шинжилгээний урвалж                   | Хүн    | 1 багц | 276000 | 276,000          |
| 21                     | Улаан вакум тенр                            | Хүн    | 30     | 48000  | 48,000           |
| 22                     | Ягаан вакум тенр                            | Хүн    | 30     | 48000  | 48,000           |
| 23                     | Шинжилгээний зүү                            | Хүн    | 30     | 150000 | 150,000          |
| 24                     | Элэгний В вирусын оношлуур                  | Хүн    | 30     | 1200   | 36,000           |
| 25                     | Элэгний С вирусын оношлуур                  | Хүн    | 30     | 1800   | 54,000           |
| 26                     | ДОХ тест                                    | Хүн    | 200    | 2800   | 560,000          |
| 27                     | Тэмбүү тест                                 |        | 200    | 2100   | 420,000          |
| 28                     | Зүрхний цахилгаан бичлэгийн Принтерийн цаас | ширхэг | 5      | 3200   | 16,000           |
| 29                     | Эхо гель                                    | ширхэг | 3      | 6500   | 19,500           |
| Эрүүл мэндийн бүгд     |                                             |        |        |        | <b>2,639,500</b> |
| Е.Бичиг хэргийн зардал |                                             |        |        |        |                  |
| 30                     | Бичгийн цаас А4                             | Ширхэг | 4      | 20,000 | 80,000           |
| 31                     | Принтерийн хор                              | ком    | 1      | 30000  | 30,000           |
| 32                     | Бал                                         | Ширхэг | 15     | 1000   | 15,000           |
| 33                     | Харандаа                                    | Ширхэг | 15     | 500    | 4,500            |
| 34                     | Үдээсний машин                              | Ширхэг | 4      | 5000   | 2,000            |
| 35                     | Балалуур                                    | Ширхэг | 4      | 500    | 2,000            |
| 36                     | Цавуу                                       | Ширхэг | 4      | 2500   | 10,000           |
| 37                     | Скоч                                        | Ширхэг | 10     | 3000   | 30,000           |
| 38                     | Зарлан дуудах мэдэгдэл хэвлүүлэх            | Ширхэг | 250    | 160    | 40,000           |
| 39                     | 4-р маягт (татагдагчийн анкет)              | Ширхэг | 100    | 160    | 16,000           |
| 40                     | 12-р маягт (Тооцооны хуудас)                | Ширхэг | 100    | 160    | 16,000           |
|                        |                                             |        |        |        | <b>245,000</b>   |
| Ё.Бусад зардал         |                                             |        |        |        |                  |
|                        | Холбооны зардал                             | нэгж   | 8      | 10000  | 80,000           |
|                        | Гарын шингэн саван                          | Ширхэг | 2      | 2500   | 5,000            |
|                        | Арц хүж, агааржуулагч                       | Ширхэг | 6      | 6000   | 36,000           |
| Бусад зардлын бүгд     |                                             |        |        |        | <b>121,000</b>   |
| НИЙТ ДҮН               |                                             |        |        |        | <b>6,567,800</b> |